



**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024.01.12

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай байгуулсан “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тус газрын үйл ажиллагаанд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулах замаар яам болон “АТҮГ” ТӨҮГ-ын удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн бодлого, шийдвэр, төлөвлөгөөнд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримталсан.

Тус газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгийг хамруулсан. Үүнд:

- “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
- Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
- Шилэн дансны мэдээлэл;
- Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтийг хамрууллаа.

Гурав. Танилцуулга

Тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ дээрх 5 үзүүлэлтээр дүгнэлээ. Үүнд:

3.1. “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс 7 чиг үүргийг гэрээний үндсэн дээр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т шилжүүлэн гүйцэтгүүлж байна.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г жил бүр байгуулж, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ажиллаж байна.



Уг төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ тусгаснаас 2023 оны жилийн эцсийн байдлаар “үр дүнтэй” буюу бүрэн хэрэгжсэн 32, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувьтай 19, 70 хувьтай 4, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай 1, “үр дүнгүй” буюу 30 хувьтай 5, үнэлгээнд ороогүй 2 арга хэмжээ байгаа ба төлөвлөгөөний хэрэгжилт 88.4 хувьтай байна.

“Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар хүснэгтээр харуулбал:

№	Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/						Биелэлт /хувиар/
		100	90	70	50	30	0	
1	63	32	19	4	1	5	-	88.4

“Үр дүнгүй” буюу 30 хувьтай 5 арга хэмжээ:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт
1	3.1.1 Ховд болон Орхон, Говьсүмбэр аймагт автобуудлын барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах	4-р улиралд: Говьсүмбэр, Орхон аймгийн Автобуудлын барилгыг ашиглалтад оруулсан байна.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Говьсүмбэр аймгийн автобуудлын барилгыг барих талаар үйлдвэрийн газраас ТӨБЗГ-т хүсэлт гаргасан бөгөөд ЗТХЯ-наас дэмжлэг авч, шийдвэрлүүлэх чиглэл өгсөн. ЗТХЯ-нд 2023.03.21-ний өдрийн 1/325 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. Говьсүмбэр аймгийн автобуудал барилгын ажил эхлээгүй газрын асуудал яригдаж байна. Орхон аймгийн автобуудлын барилгын ажлын гүйцэтгэл 85%-тай төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. “Зорчигч тээврийн Ховд” ХХК нь өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90%-тай /байна.
2	3.1.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах	4-р улиралд: Авто зам дагуух 10 байршилд үйлчилгээний цогцолбор ашиглалтад оруулсан байна.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах талаарх судалгааг хийн ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. Үүнээс нийт 47 байршил байгуулах санал БОЯЖА болон ЗТХЯ-ны хамтарсан ажлын хэсгээс гарсан бөгөөд ЗТХЯ-наас 47 байршилд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Хүсэлт гаргасан болон сонгон шалгаруулалтын талаар мэдээлэл авахыг хүссэн 20 аж ахуй нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн бөгөөд 47 байршлаас 2023 онд ашиглалтад орсон 6 байршлын ААНБ-уудтай хамтран, дэмжин ажиллаж байна.
3	3.1.3 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулсан хуулийн этгээдүүдийг бодлогоор дэмжих, хамтран ажиллах	2-4-р улиралд: Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээний биелэлтийг хангуулсан байна.	Тус үйлдвэрийн газар нь ашиглалтад орсон Төв аймгийн Баян суманд байрлалтай “Альфа рөүд” ХХК-ний Баянмонгол цогцолбортой 2022.12.22-ны өдөр 03 тоот гэрээ байгуулсан бөгөөд “УБ-Дг.Сайншанд” болон “УБ-БНХАУ.Эрээн” чиглэлүүдийг тухайн зам дагуух байгууламжаар үйлчлүүлэн ажиллаж байна. Үйлдвэрийн газрын 21 аймгийн автотээврийн төвийн дарга нарыг оролцуулсан цахим хурлыг 2023 оны 03 дугаар сарын 16-ний өдөр зохион байгуулсан бөгөөд холбогдох стандартын шаардлага хангасан авто замын дагуух үйлчилгээний байгууламжтай ААН-тэй гэрээ байгуулж ажиллах, хүсэлт ирүүлсэн иргэн ААНБ-д бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллах талаарх зөвлөмж хүргүүлсэн. 2023.05.17-ны өдөр ЗТХЯ болон “Зам, дагуух үйлчилгээний цогцолборын нэгдсэн холбоо ТББ хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ЗТХ-ийн мэргэжилтэн Б.Баярмагнай орж, төр



			хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Хөвсгөл аймаг, Орхон аймгийн зам дагуух ашиглалтад орсон зам дагуух үйлчилгээний цогцолборуудтай танилцан, мөн шинээр баригдах үйлчилгээний цогцолборуудын цэгийг сонгон батлах, сонгосон цэгүүд дээр баригдах цогцолборуудын газар олголт дээр нь дэмжлэг үзүүлэх ажлуудыг хамтран хийж ажилласан. 2023.05.24-ний өдөр тус ажлын хэсэг Хэнтий, Сүхбаатар аймгуудын чиглэлд ажилласан бөгөөд хийгдсэн ажлуудын тайланг гарган ЗТХЯ-нд хүргүүлж, тайлагнасан. Гэрээт газруудад зогсож үйлчлүүлэхгүй байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад удаа дараа мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг хангахгүй байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын асуудлыг тус үйлдвэрийн газрын захирлын 2022 оны А/101 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн хариуцлага тооцон ажиллаж байна. 2023.12.08-ны өдрийн байдлаар ажлын хэсгийн хурлаар гэрээт 4 ААНБ-д хариуцлага тооцсон.
4	4.1.1 Дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	4-р улиралд: Системүүдийг 100% үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн байна.	Дотоодын ачаа тээврийн logistic.transdep.mn программ хангамжийг боловсруулан 2021.04 дүгээр сард вэб хувилбарыг нэвтрүүлсэн мөн мобайл гар утасны аппликейшнийг 2022.03-р сард андройд гар утсанд зориулагдсан хувилбарыг "Playstore"-д байршуулан ашиглаж байна. Хот хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж буй ААНБ-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, ачааны төрлийн тээврийн хэрэгслийг www.logistic.transdep.mn сайтаар дамжуулан хянах боломжийг бүрдүүлэн ажиллах, ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх ажлыг идэвхжүүлэх чиглэлээр санал солилцох онлайн хурлыг 2023.03.02-06-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд дээрх хурлаас системийг шинэчлэх шаардлага үүссэн бөгөөд орон нутаг салбар төвүүдээс ирсэн саналыг нэгтгэсэн. Системийн шинэчлэл 80%-ийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны 12 сарын 10-ны байдлаар: 1. УБ-Даланзадгад-УБ чиглэлд "Буян цог оршвой ХХК"-тай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна. 2023.12.10-ны байдлаар 110,6 тонн ачааг бүртгэлжүүлэн хяналт тавьж ажиллаж байна. 2. УБ-Хөвсгөл-УБ чиглэлд "Нөхөрлөл зам", "Наран логистик" ААН-үүдтэй 2023 оны 01 дүгээр сард сарын хугацаатай гэрээ байгуулсан. Мөн 2023 оны 05 дугаар сард "Хос билэг девелопмент энд констракшн" ХХК, "Чингүн хурд транс" ХХК-тай тус тус гэрээ байгуулан 2023.12.10-ний байдлаар 722 тонн ачааг бүртгэлжүүлэн хяналт тавьж ажиллаж байна.
5	4.1.4 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID)-г бүрэн нэвтрүүлж, татвар даатгал, төлбөр тооцоо, бүртгэл хяналтын үйл	I-IV улирал: Монгол Улсын хэмжээнд нийт 1 сая тээврийн хэрэгсэлд RFID tag-ийг байршуулна. Олон улс, улсын чанартай 27 ТАЦ-ийг цахимжуулах ажил хийгдэнэ.	Төрийн үйлчилгээ хурдан шуурхай хүргэх, тээврийн хэрэгслийн мэдээллийг цахимжуулах, шинэчилсэн бүртгэлд хамтруулах, авто замын хөдөлгөөн зохион байгуулалт болон зохицуулалтыг автомат хэлбэрт шилжүүлэх, тээврийн хэрэгслийг дата загварт оруулах, олон улсад амжилттай хэрэгжиж, туршигдсан RFID (Radio-frequency identification) болон дугаар таних LPR технологиудыг ашиглан, хэрэгжүүлж эхлээд байна. "Автотээврийн Үндэсний Төв" ТӨҮГ-ын хувьд техник хяналтын цахим гэрчилгээний загвар тодорхойлох, шошгоны техникийн шаардлага боловсруулах ажлын хэсэгт хамтран ажиллалаа. ТЕХНИК ХЯНАЛТЫН ХЭРЭГСЛИЙН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭНИЙ RFID ШОШГОНЫ СУДАЛГАА



	ажиллагааг сайжруулах	Тус үйлдвэрийн газраас Нийслэлийн мэдээллийн технологийн газар болон "Бодь-Электроникс" ХХК-тай хамтран RFID шошго судлах ажлын хүрээнд БНХАУ-ын Шанхай хотноо шошго үйлдвэрлэгчийн шошгыг судалж тестлэх ажлыг хамтран гүйцэтгэлээ. RFID ШОШГО БҮРТГЭЛИЙН СИСТЕМ Мөн RFID шошго бүртгэлжүүлэх гар утасны апп хөгжүүлсэн бөгөөд тус систем нь автотээврийн хэрэгслийн цонхонд байршуулсан шошгыг уншигч төхөөрөмжөөр таниулан тухайн тээврийн хэрэгслийн мэдээллийг шалган бүртгэлжүүлэх бөгөөд тухайн тээврийн хэрэгсэлд шошго суурилуулсан фото зураг авч баталгаажуулан бүртгэл үүсгэн ажиллаж байна. RFID ШОШГО БҮРТГЭЛЖҮҮЛЭХ АЖИЛ Тус үйлдвэрийн газраас Түгжрэлийг бууруулах үндэсний хороо болон Нийслэлийн Мэдээллийн Технологийн Газартай хамтран өөрсдийн хөгжүүлсэн бүртгэлийн системээр нийслэлийн үйлчилгээний автобаазын 43 тээврийн хэрэгсэлд RFID шошго байршуулан ажилласан бөгөөд ИНЕГ-ын 87 тээврийн хэрэгсэлд шошго байршуулан туршилт тохируулгын ажил хийж гүйцэтгээд байна. RFID ШОШГО БҮРТГЭЛЖҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГАА Тус үйлдвэрийн газар нь ЗТХЯ, Түгжрэлийн бууруулах Үндэсний Хороо, НМТГ, "Бодь-Электроникс" ХХК зэрэг байгууллагуудтай туршилт тохируулгын ажлыг хамтран гүйцэтгэн ажилласан бөгөөд RFID шошго суурилуулах ажил дээр "Бодь-Электроникс" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан өөрсдийн суурин 33 цэг, явуулын 11 цэгээр нийт 126 ажилтан албан хаагчаар 447,200 орчим шошгыг Улаанбаатар хотын харьяалал бүхий тээврийн хэрэгсэлд байршуулахаар гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. 2023.12.10-ны өдрийн байдлаар "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдээр дамжуулан тайлант хугацаанд 75.724 тээврийн хэрэгсэлд RFID tag-ийг байршуулсан.
--	--------------------------	--

"Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50 хувьтай 1 арга хэмжээ:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт
1	4.1.2 Улс хоорондын байнгын ачаа тээврийн зөвшөөрлийг "e-mongolia" порталгаар олгох нөхцөлийг бүрдүүлэх;	3-4-р улиралд: Системийг 100% үйлчилгээнд нэвтрүүлж, Зөвшөөрлийг И-Монгол порталгаар олгосон байна.	Улс хоорондын байнгын ачаа тээврийн хил нэвтрэх зориулалттай "С" төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг "E-mongolia" порталаар олгох талаар 2023.02.16-ны өдөр Е-Монголиа академийн холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, түгээмэл асуугддаг асуулт, танилцуулга мэдээлэл, ачааны төрөл, уурхай нэмэх зэрэг мэдээллийг шинэчилсэн. 2023.03.03-ны өдөр "И-Монголиа"-ын академи дээр хамтарсан уулзалт зохион байгуулж С зөвшөөрлийг олгох туршилт тохируулгыг хийсэн боловч мэдээлэл солилцох явцад алдаа гарч, хөгжүүлэлт дахин хийхээр болсон бөгөөд Систем хөгжүүлэлтийн ажил 80%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Засгийн газрын 2022 оны 362 тогтоолын 5 дугаар зүйлд заасан Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд ашигт малтмалыг уурхайн ам нөхцөлөөр борлуулах шинэ гэрээ байгуулахыг зогсоож, хилийн үнээр худалдан борлуулах, байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх хэрэгжилтийн хүрээнд ЗТХЯ-наас тус



		үйлдвэрийн газартай байгуулсан Ажил, үйлчилгээ хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.2-т заасан хэсгийг хасуулах саналыг ЗТХЯ-нд 2023.10.04-ний өдрийн 1/1264 тоот албан бичгээр хүргүүлсэн.
--	--	--

“Хэрэгжих шатанд” буюу 70 хувийн үнэлгээтэй 4 арга хэмжээ:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт
1	1.2.1 Жуулчин тээврийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан зохион байгуулах Шалгуур үзүүлэлт www.e-mongolia.mn -д бүртгэлтэй жуулчин тээвэрлэгчийн тоо	2-4-р улиралд: Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-д бүртгэлтэй жуулчин тээвэрлэгчийн тоог нэмэгдүүлсэн байна.	Жуулчин тээврийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан зохион байгуулахад төрийн үйлчилгээний хур системд гацалт үүсэж E-mongolia дээр хөгжүүлэлт хийх боломжгүй талаар мэдэгдсэн тул Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг Тээврийн нэгдсэн системийн программаар дамжуулан зохион байгуулахаар болж бүрэн дууссан. 2024 оноос эхлэн ашиглахаар бэлтгэл ажлыг хангасан. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан жуулчин тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь жолооч нартай гэрээ байгуулан ажиллаж байна. 2023.12.10-ны байдлаар 89 аж ахуйн нэгж байгууллага, 175 хувь жолооч нартай гэрээ байгуулан 827 “Жуулчин” таних тэмдэг олгосон.
2	2.1.2 Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	3-4-р улиралд: Төслийн эхний шатны ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.	“Монгол Улсад тээврийн хэрэгслийн үзлэг оношилгооны чадавхыг дээшлүүлэх оношилгооны төвийг хөгжүүлснээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах төсөл”-ийн хамтарсан зөвшилцөх хороог байгуулах гэрээ 2023.09.25-ны өдөр зурагдсан. Төслийн зорилго нь Монгол Улсад замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдийн насжилтын мөчлөгийн менежментийн суурийг бий болгож, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах юм. Төслийн хүрээнд эхний шатны ажлуудыг хэрэгжүүлж, 2023 оны 04 дүгээр улиралд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: - Бодлогын зөвлөмж - Засварын гүйцэтгэгчийг шалгаруулах/ төлөвлөлт Тоног төхөөрөмжийг сонгох/ гүйцэтгэгчийг сонгох



3	4.2.1 Байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн, албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.	3-4-р улиралд: Тоон гарын үсгийн хэрэглээг албан хэрэг хөтлөлтөд 100% ашигласан байна.	2022.11.01-ний өдрөөс “Үндэсний Дата Төв” УТУГ- нь Цахим гарын үсгийн тухай хуулийн 34-р зүйл, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/28 дугаар тушаал болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгохгүй болсон. Иймд цаашид үйлдвэрийн газар нь Үндэсний дата төвөөс тоон гарын үсэг шинээр авах болон сунгалт хийх боломжгүй болсон. Үндэсний дата төвөөс өгсөн зөвлөмжийн дагуу 2023 оны 1-р улирлын байдлаар “Тридиум и-Секюрити” ХХК-ийн тоон гарын үсгийг сонгон 8 тоон гарын үсгийг тус үйлдвэрийн газрын удирдлага, албан хаагчдад авч өгсөн. Мөн тухайн шинэ тоон гарын үсгийг ашиглах заавар зөвлөгөөг өгч, практик сургалт явуулж ажилласан. Бусад байгууллагууд руу тоон гарын үсгээр баталгаажуулсан албан бичиг солилцох боломжийг бүрдүүлсэн. Тус үйлдвэрийн газраас шинээр гаргахаар төлөвлөж байгаа AUTOBOX гар утасны аппликейшнд GSign тоон гарын үсгийн технологийг нэвтрүүлж, иргэдээс ирэх цахим хүсэлтийг баталгаажуулах, цахим технологийг нэвтрүүлсэн. Иргэд өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлэх үйлчилгээг Төрийн ТУЦ машинаар авах боломжийг EMongolia, Үндэсний Дата Төв зэрэг төрийн байгууллагуудтай хамтарч нэвтрүүллээ. Уг үйлчилгээг нэвтрүүлэхэд Иргэний үнэмлэх болон Иргэний гар утас ашиглан тоон гарын үсэг зурах технологийг нэвтрүүллэн.
4	5.1.7 Байгууллагын дотоод хяналтыг зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	4-р улиралд: Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 90-ээс дээш хувь биелсэн байна.	2023.01.10-ны өдөр тус үйлдвэрийн газрын дотоод хяналт, шалгалтын 2023 оны төлөвлөгөөг үйлдвэрийн газрын захирлаар батлуулан ажиллаж байна. Мөн орон нутгийн салбар төвүүдийн 2023 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг төвийн дарга нараар батлуулан 1 дүгээр улирлын биелэлт нэгтгэн авахаар ажиллаж байна. Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд 2023.01.26-27-ний өдрүүдэд Улаанбаатар хот дахь Баянгол, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд, 2023.02.17-нд Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд, дэнжийн 1000 техникийн хяналтын үзлэгийн төвд, 2023.03.03-ны өдөр Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төв, зорчигч тээврийн төв, “Да хүрээ зах” дахь тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд зохих журам төлөвлөгөөний хүрээнд хяналт шалгалтыг тогтмол тавьж байна. 2023.03.22-ны өдөр Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд хяналт шалгалт хийсэн. Мөн 2023.04.04-ний өдөр Улаанбаатар хот, орон нутаг дахь нийт 28 салбар төвүүдэд дотор болон гадна талын хяналтын камерын системийн холболтыг нэвтрүүлж, ХШДАА-наас өдөр тутмын хяналт шалгалт, ажлын цаг ашиглалтыг камерын хяналтын системээр хянах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн тус албанд дотоод хяналт шалгалтын хүрээний 6 өргөдөл гомдол ирснийг холбогдох журмын хүрээнд хяналт шалгалт хийж, хариуг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. 2023.06.27-ний өдөр ЗСХНХ-тэй хамтран цаг ашиглалтын талаар хийгдсэн гэнэтийн шалгалтаар нийт 96 ажилтан хамрагдсан. 2023.04.20-нд СХТХҮТ, СХЗТТ-д, 2023.05.08-нд болон 2023.08.15-нд тус бүр салбар нэгж төвүүдэд цаг ашиглалт



		болон дотоод хяналт шалгалт хийсэн бөгөөд заавар зөвлөгөө өгч ажилласан. 2023 оны 11 дүгээр сард СХЧУТ, СХТХУТ зэрэг салбаруудад цаг ашиглалт болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар дотоод хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчилд зөвлөгөө өгч ажилласан болно. 2023.12.05-ны байдлаар ААНБ, иргэдээс ирүүлсэн 7 санал хүсэлт, өргөдөл гомдлын дагуу хяналт шалгалт хийж, хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн, "Хөдөлмөрийн дотоод журам" зөрчсөн, албан тушаал /ажлын байр/-ны тодорхойлолтын холбогдох заалтуудыг биелүүлээгүй 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах тухай санал, дүгнэлтийг ЗСХНХ-т хүргүүлэн ажиллалаа.
--	--	--

3.2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд автотээврийн чиглэлээр 4 арга хэмжээ тусгагдсанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй 1, 50 хувийн хэрэгжилттэй 1, хэрэгжээгүй 2 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар 37.5 хувьтай байна.

Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилт (хувиар)						Биелэлт (хувиар)
	100	90	70	50	30	0	
4	1	-		1	-	2	37.5

"Хэрэгжээгүй" буюу 0 үнэлгээтэй 2 арга хэмжээ

1. 3.6.3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэл болон орон нутагт ачаа, зорчигч тээврийн зориулалт бүхий терминалуудыг байгуулна. 1. Замын-Үүд, Сэлэнгэ, Булган, Орхон, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн автобуудал байгуулна.

Зорилтот түвшин: Дорнод, Дундговь, Сүхбаатар аймгийн автобуудал ашиглалтад оруулна.

Хэрэгжилт:

1. "Өв хангамж групп" ХХК нь автобуудал барих газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

2. Улсын төсвийн 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд Орхон аймгийн төвд автобуудлын барилга барих тендерт "Шинжүү" ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 90 хувьтай 3,040,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

3. "Ховд зорчигч тээвэр" ХХК өөрийн хөрөнгөөр Ховд аймагт барьж байгаа зорчигч тээврийн автобуудлын барилга угсралтын ажил 80 хувьтай байна. Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж барилга материалын өсөлтөөс шалтгаалан ашиглалтад оруулах хугацааг 2024 оны II улирал хүртэл хойшлуулсан.

4. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутагт барьж буй олон улсын Зорчигч тээврийн автобуудлын барилгыг үргэлжлүүлэн барих боломжтой эсэхэд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, барих төсөвт өртгийг тооцох ажлуудыг "АТҮТ" ТӨҮГ хийлгэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 2024 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бариулах сонгон шалгаруулах ажил хийж байна.

5. 2024 оны улсын төсөвт Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн автобуудал барих хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн.

6. Хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй тул Сэлэнгэ, Булган, Дундговь, Өвөрхангай аймгуудын зорчигч тээврийн үйлчилгээг "АТҮТ" ТӨҮГ-ын техникийн хяналтын үзлэгийн байрнаас, Говьсүмбэр, Дорнод аймгийн зорчигч тээврийн үйлчилгээг түрээсийн байрнаас үзүүлж байна.



7. Сүхбаатар аймгийн зорчигч тээвэрлэлтийг "АТҮТ" ТӨҮГ-ын эзэмшлийн хуучин байрнаас үйлчилгээ үзүүлж байна.

II. 3.6.3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэл болон орон нутагт ачаа, зорчигч тээврийн зориулалт бүхий терминалуудыг байгуулна. 2. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, Гашуунсухайт боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулна.

Зорилтот түвшин: Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь

Хэрэгжилт: Зүүн бүсийн тээвэр, логистикийн хувьд нийслэлийн зүгээс 2022 онд Туушин ХХК-тай санамж бичиг байгуулсан. 2023 оны 01 дүгээр сард уг төсөлд санхүүжилт татах зорилгоор БНХАУ-ын Тяньжин хотын боомтын удирдлагуудтай Улаанбаатар хотод уулзалт зохион байгуулсан. 2023 оны 04 сарын 20-ны өдөр Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК "Туушин" ХХК-тай хамтран Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурсан. Төслийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд 2023 оны 3 дугаар улирлаас барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Улаанбаатар хотын баруун хэсгийн тээвэр, логистикийн төвийн хувьд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Олон улсын худалдаа логистикийн төв ХК, БНХАУ-ын Чайна Рэйлвэй Констракшн Корпорэйшн ХХК нар Улаанбаатар хотын баруун бүсийн тээвэр логистикийн төв байгуулах төслийн ТЭЗҮ-ийг хамтран боловсруулах, цаашлаад төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр санамж бичигт талууд гарын үсэг зурагдсан.

"Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

I. 3.4.6. Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. 2. Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 200 км тутамд үйлчилгээний цогцолбор, 100 км тутамд амрах талбай байгуулах төслийг эхлүүлнэ.

Хэрэгжилт: Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах зорилтын хүрээнд дараах байршлуудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто зам дагуух үйлчилгээний цогцолборыг байгуулж ашиглалтад оруулсан. Үүнд:

1. Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд "Инсун мод" ХХК,
2. Завхан аймгийн Сонгино суманд "Титан Би" ХХК,
3. Архангай аймгийн Цэнхэр суманд "Заяын өгөөж" ХХК,
4. Булган аймгийн Хутаг өндөр суманд "Уньтын рашаан" ХХК,
5. Төв аймгийн Баянцагаан суманд "Мандах бадрах булаг" ХХК

Дээрх цэгүүдийг БОАЖЯ болон "АТҮТ" ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, хот хоорондын нийтийн тээврийн хуваарь цаг болон аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээ авах байгууллагуудын жагсаалтад оруулан ажиллаж байна.

ЗТХЯ, БОАЖЯ, МҮХАҮТ, Монголын аялал жуулчлалын холбоод хамтран авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах зорилгоор хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2023 онд 28 байршилд 27 аж ахуйн нэгж авто замын дагуух үйлчилгээний цогцолбор байгуулахаар МҮХАҮТ-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан. 2023 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 7 байршилд үйлчилгээний цогцолборыг байгуулж ашиглаж байна. Үүнд:

1. Хэнтий аймгийн Жаргалтхаан сум, Хэрлэн сум, Чингис хотод С ангиллын цогцолбор,
2. Булган аймгийн Хутаг-Өндөр сум, Булган аймгийн Рашаант сум Элсэн тасархай В ангиллын цогцолбор,
3. Дархан-Уул аймгийн Дархан-Эрдэнэтийн уулзварт,
4. Дорноговь аймгийн Замын үүд боомтод,
5. Ховд аймгийн Манхан сумын нутаг дэвсгэр дэх АН-4 авто замын 4 замын уулзварт байгуулсан.



“Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2023.11.21-ний өдрийн хуралдаанаар газар, хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээг Засгийн газраар шийдвэрлүүлэх Үндэсний хорооны 3 дугаар хуралдааны тогтоол батлуулсан. Уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулахаар ЗГХЭГ-т хүргүүлэв.

3.3. Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тайлант хугацаанд тус газраас хариуцан хэрэгжүүлэх 4 арга хэмжээ байгаагаас 100 хувийн хэрэгжилттэй 1, 70 хувийн хэрэгжилттэй 1, 50 хувийн хэрэгжилттэй 1, тасарсан 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилтийн дундаж 55.0 хувьтай байна.

Нийт арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)							Биелэлт (Хувиар)
	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
4	1	-	1	1	-	1	-	55.0

“Хэрэгжээгүй” буюу 0 үнэлгээтэй 1 арга хэмжээ

2.4. Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулна.

Зорилтот түвшин: III-IV улирал: ТЭЗҮ зураг төсөл боловсруулж барилга байгууламжийн ажлыг эхлүүлж 40 хувьд хүргэнэ.

Хэрэгжилт: Коронавируст халдвар COVID-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн 43 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2021.02.26-ны өдрийн А-1/354 дүгээр албан даалгаврын дагуу ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах боломжгүй болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэлд зорчигч тээврийн зориулалт бүхий терминалуудыг байгуулна” гэж тусгагдсаны дагуу “Концессын тухай хууль”-ийн 10.3 дах заалтын дагуу Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүрэгт байгуулагдах автобуудлын нөхцөл байдал, үр ашгийн тооцооллыг хийн 2021.10.29-ний өдрийн 2/1378 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

2.4. Ачаа болон такси үйлчилгээний тээврийн үйлчилгээнд одоо ашиглаж байгаа программаас мэдээлэл авч нэгдсэн тайлан гаргадаг систем хөгжүүлсэн байна.

Зорилтот түвшин: I-IV улирал: Хот болон хот орчмын тээвэрлэгдэж байгаа ачаа тээврийн үйлчилгээг бүртгэлжүүлэх, хяналтыг хэрэгжүүлнэ. Такси үйлчилгээний компаниудын одоо ашиглаж байгаа программуудаас мэдээлэл авч нэгдсэн тайлан гаргадаг систем хөгжүүлнэ.

Хэрэгжилт: Хот хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, ачааны төрлийн тээврийн хэрэгслийг www.logistic.transdep.mn сайтаар дамжуулан хянах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн сан үүсгэх, Ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх ажлыг идэвхжүүлэх чиглэлээр санал солилцох онлайн “zoom” хурлыг 2023.03.02-06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Орон нутаг салбар төвүүдээс ирсэн саналыг нэгтгэн logistic.transdep.mn сайтыг өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Системийн шинэчлэл 80%-ийн гүйцэтгэлтэй байна.



“Хэрэгжих шатанд” буюу 70 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ:

4.2. Авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх хог хаягдлыг боловсруулах нэгдсэн сүлжээг бий болгоно.

Зорилтот түвшин: II-IV улирал: Автотээврийн хэрэгслээс үүсэх хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх,

Хог хаягдлыг дахин боловсруулах явцад гарсан сэлбэг хэрэгслийн эдэлгээний нөөцийг тогтоох лаборатори байгуулах хөрөнгийн асуудал, газрын асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлж хяналт тавих

Хэрэгжилт: Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 433 авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэж байгаа хог хаягдлын судалгааг авч, холбогдох саналыг боловсруулан ЗТХЯ-ны АТБХЗГ-т 2023.05.26-ны өдрийн 1/725 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3.4 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн веб сайтад төсөв, гүйцэтгэлийн чиглэлээр 14, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендэрийн чиглэлээр 6, бусад чиглэлээр 8, нийт 3 чиглэлийн хүрээнд 28 төрлийн мэдээ байршуулахаас 21 төрлийн мэдээг цаг хугацаандаа байршуулсан, 7 мэдээллийг байршуулах байхгүй ба хэрэгжилт 100.0 хувьтай байна.

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Хэрэгжилтийн дундаж хувь	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Хугацаа болоогүй (төрлийн тоо)	Оруулах мэдээлэлгүй
				100	90	70	50	30	0		
1	Төсөв, гүйцэтгэл	14	100.0	9	-	-	-	-	-	-	5
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	100.0	4	-	-	-	-	-	-	2
3	Бусад	8	100.0	8	-	-	-	-	-	-	-
Дүн		28	100.0	21	-	-	-	-	-	-	7

3.5 Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Үүнээс /хувиар/					Хэрэгжилтийн дундаж хувь
			100	70	30	0	Хамаарал-гүй	
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	4	2	2	-	2	75.0
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	4	-	-	2	-	66.7



3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	12	1	-	1	1	90.7
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	1	-	-	-	1	100.0
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	6	-	-	1	6	85.7
Дүн		46	27	3	2	4	10	85.5

“Хэрэгжээгүй” буюу 0 үнэлгээтэй 4 арга хэмжээ:

2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам,

2.5. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ,

3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл,

5.6. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшуулалын дүн, албан цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах

Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:

1.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт,

1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.

“Хэрэгжих шатанд” буюу 70 хувийн үнэлгээтэй 3 арга хэмжээ:

1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн,

1.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг,

3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааг 2023 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 88.4 хувьтай, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 37.5 хувьтай, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан санамж бичгийн биелэлт 55.0 хувьтай, Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ 100.0 хувьтай, мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 85.5 хувьтай байх бөгөөд 5 үзүүлэлтийн дундаж үнэлгээ нь 86.0 хувь байна.



Дөрөв. Дүгнэлт

Дээрх 5 үзүүлэлтийн хүрээнд нийт 148 арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхэд "үр дүнтэй" буюу "бүрэн хэрэгжсэн" 82, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90 хувьтай 19, "хэрэгжих шатанд" буюу 70 хувьтай 8, "эрчимжүүлэх шаардлагатай" 50 хувьтай 3, "хэрэгжилт хангалтгүй" 30 хувьтай 7, "үр дүнгүй" буюу хэрэгжээгүй тасарсан 7, үнэлгээнд ороогүй 2, оруулах мэдээлэл байхгүй 7, хамааралгүй 10 арга хэмжээ байгаа ба дундаж үнэлгээ 86.0%-тай байна.

"Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх төлөвлөгөөнөөс 12 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт болон Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлэн ажиллажээ.

Тав. Санал, зөвлөмж

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төлөвлөгөөнд туссан ажлыг сайжруулан, дэвшүүлсэн зорилтод хүргэхэд анхаарах;
2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд автотээврийн чиглэлээр туссан арга хэмжээний биелэлтийг хэрэгжүүлэхэд бодитой ахиц гаргах;
3. Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан өөрийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг 2024 оны "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-нд бүрэн тусгаж, зорилтот түвшнийг ижил төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллах;
4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай "Хамтран ажиллах гурвалсан гэрээ" байгуулж, гэрээний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
5. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох хүрээнд тус байгууллагад хамаарал бүхий мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангах;
6. Тус байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан байгууллагынхаа гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг албан бичгээр ирүүлэх;
7. Бүрэн хэрэгжсэн ч тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, хоёр мянган тэмдэгтэд багтаан ажлын үйл, явц тоочилгүй, огноог тодорхой дурдан, зөв бичгийн дүрмийн алдаагүй тайлагнаж хэвших;
8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ

Тус газрын 2023 оны "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэнийг хавсаргав.

ТАНИЛЦСАН:

САЙД

С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Э.МӨНХНАСАН

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Б. ГҮРСОРОНЗОН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

А.МӨНХБАТ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Л.ШИНЭЧИМЭГ



ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН 2023 ОНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

/Жилийн эцсийн байдлаар/

/Жилийн эцсийн байдлаар/													
№	Хяналтанд байх арга хэмжээ	2023 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилт (хувиар)									
				Дундаж	100	90	70	50	30	0	Үнэлгээнд ороогүй	Оруулах мэдээлэл байхгүй	Хамааралгүй
1	Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилт	63	63	88.4	32	19	4	1	5	-	2	-	-
2	Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	4	4	37.5	1	-	-	1	-	2	-	-	-
3	Санамж бичгийн хэрэгжилт	4	4	55.0	1	-	1	1	-	1	-	-	-
4	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	28	21	100.0	21	-	-	-	-	-	-	7	-
5	Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт	46	36	85.5	27	-	3	-	2	4	-	-	10
Нийт		145	126	86.0	82	19	8	3	7	7	2	7	10